



**№1.25 ТАРИМАЛ УРГАМЛЫН ҮР ҮЙЛДВЭРЛЭЛ  
БОЛОН НИЙЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШАЛГАХ  
ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хяналтын байгууллага:

Шалгуулагч этгээдийн нэр:

Объектын нэр:

Регистрийн дугаар:

Хяналт шалгалт хийсэн огноо:...../...../.....

Шаардлага хангасан  
асуултын тоо:

Хууль сахин  
мөрдөлтийн хувь:

Шаардлага хангаагүй  
нийт оноо:

Эрсдэл үүсэх  
магадлалын хувь:

Эрсдэл үүсэх  
магадлал

**ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ**

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
1	2	3	4	5	6	
<b>Нэг.Үр үйлдвэрлэгчийн тариалангийн талбайн хамгаалалт, баримт бичгийн бүрдүүлэлт</b>			<b>0</b>	<b>45</b>		
1.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг	Үр үйлдвэрлэлийг тусгай зөвшөөрөлтэй этгээд эрхлэх бөгөөд уг тусгай зөвшөөрлийг тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгосон	0	5		
2.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг	Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь харьяалах нутаг дэвсгэр дэх хяналтын байгууллагын мэдээллийн санд бүртгүүлсэн	0	5		
3.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.1 дэх заалт	Үрийн тариалан эрхлэх талбайтай	0	5		
4.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалт	Үр үйлдвэрлэлийн иж бүрэн техниктэй	0	5		

5.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалт	Үтрэмийн талбай, үрийн агуулах, эсхүл эх ургамал хадгалах зоорьтой	0	5		
6.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалт	Үр үйлдвэрлэлийн чиглэлээр мэргэшсэн агрономичтой	0	10		
7.	Тариалангийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг	Цахим мэдээллийн санд тариалалт, хураалт, ургацын мэдээллийг бүрэн оруулсан	0	5		
8.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг	Үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 4.1-т зааснаас гадна үржүүлэх үрийн төрөл, үр үйлдвэрлэх бүс нутгийг тусгасан	0	5		
<b>Хоёр.Газар тариалангийн үйлдвэрлэлд үр үйлдвэрлэгчийн үүрэг</b>			<b>0</b>	<b>85</b>		
9.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт	Өөрийн үйлдвэрлэсэн үрийн дээжийг хөндлөнгийн итгэмжлэгдсэн үрийн лабораторийн чанар, хорио цээрийн хяналтын шинжилгээнд хамруулж, хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлт гаргуулсан	0	5		
10.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг	Үр үйлдвэрлэлийн талбай бүрд таримал ургамлын төрлөөс хамааруулан үр боловсрох үед сортын хянан баталгааг хийлгэсэн	0	10		
11.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт	Хамгаалагдсан сортын үр үйлдвэрлэх бол сортын бүтээгчийн зөвшөөрлийг авсан	0	5		
12.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалт	Сортын үндэсний бүртгэлд бүртгэгдсэн нутагшсан болон ирээдүйтэй сортын үрийг үржүүлгийн бүдүүвчийн дагуу үржүүлдэг	0	5		
13.	Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.11 дэх заалт, GAP /ХАА-н зохистой дадал/	Талбайн түүх хөтөлсөн /сүүлийн 5 жилээр/	0	5		
14.	Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх хэсэг, GAP /ХАА-н зохистой дадал/	Тариалангийн газрын хөрсний үржил шимийг хамгаалж сайжруулдаг	0	10		
15.	Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт	Өөрийн эзэмшлийн талбай, ургацаа бусдын халдлага болон малаас хамгаалсан /малын бэлчээрт ойрхон талбайг хашиж хамгаалсан/	0	5		
16.	Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалт	Байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, сэлгэн тариалалтыг зохих түвшинд хадгалсан	0	5		
17.	Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн	Өөрийн эзэмшил, ашиглалтад байгаа тариалангийн газарт	0	5		

	20.2.8 дахь заалт, ХАА-н зохистой дадал /GAP/	хуульд заасан хугацаанд агрохими, агрофизикийн шинжилгээ хийлгэсэн /5 жил тутамд 1 удаа хийлгэсэн/				
18.	Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.12 дахь заалт, Газар тариалангийн зохистой дадал нэвтрүүлэх зөвлөмжийн 2.4 дэх заалт	Эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийн дагуу тариалангийн технологийг мөрддөг	0	5		
19.	Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалт	Таримлын төрөл тус бүрээр тариалсан болон хураасан ургац, бэлтгэсэн уринш талбайн ашиглалтын талаарх мэдээг сум дүүргийн Засаг даргад тухай бүр гаргаж өгдөг	0	5		
20.		Тариалалт хураалтын мэдээг өдөр бүрээр мэдээлсэн бүртгэл хөтөлсөн дэвтэртэй	0	5		
21.	Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйл	Мал тэжээвэр амьтан оруулах, бэлчээх, дайран өнгөрөх зам гаргах, өвс, сүрэл шатаах, ан ав хийдэггүй	0	5		
22.	Тариалангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг	Тариалангийн талбайн захаас гадагш 500 метрийн зайд мал бэлчээх, оторлох болон бэлчээрийн мал аж ахуйн өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржаагүй	0	5		
23.	Тариалангийн тухай хуулийн 25 дугаар зүйл	Тариалангийн талбайг хаших, ойн зурвас байгуулах, талбайд сүрлэн хучлага тогтоох, өвчин хортон, хог ургамал болон ганд тэсвэртэй нутагшсан, ирээдүйтэй сортын үрээр тариалах, эрдэс, органик бордоо ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, төлөвшүүлэх, усалгааны горим мөрдөх, талбайн түүхэнд хөрс хамгааллын арга хэмжээг тусган хөтөлж хэвшсэн	0	5		
<b>Гурав.Таримлын үрийн чанарын хяналт, баталгаажуулалт</b>			<b>0</b>	<b>70</b>		
24.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг	Эрдэм шинжилгээний байгууллага тухайн сортыг бүтээсэн бүтээгчийн хяналтын доор анхан шатны үрийн материал болгон үржүүлсэн үрийг цөм үрд тооцуулсан	0	3		
25.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг	Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага тусгай зөвшөөрөлтэй үрийн аж ахуйд үржүүлсэн цөм үрийг хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас стандартын шаардлага хангасныг тогтоож торгон үрд тооцуулсан	0	3		
26.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг	Тусгай зөвшөөрөлтэй үрийн аж ахуйд үржүүлсэн торгон үрийг хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны	0	3		

		байгууллагаас стандартын шаардлага хангасныг тогтоож баталгаажсан үрд тооцуулсан				
27.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэг	Эрлийз сортын үрийг баталгаажсан үртэй адилгаж үзсэн	0	3		
28.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсэг	Энэ хуулийн 5.2, 5.3-т заасан үрд хөндлөнгийн лаборатори шинжилгээ хийж, шинжилгээний дүнг үндэслэн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага баталгаажуулсан	0	3		
29.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг	Хянан баталгааны дүнгээр шаардлага хангасан талбайгаас хураасан ургацаас дээж авч шинжилгээнд өгч, шинжилгээний дүнг үндэслэн хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх бүхий улсын байцаагчаар дүгнэлт гаргуулсан	0	10		
30.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг	Хянан баталгааны дүн болон улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн тухайн ангиллын стандартын шаардлагад нийцсэн үрийн цуврал бүрийг баталгаажуулсан тариалангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрчилгээтэй	0	5		
31.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг	Холбогдох стандартын шаардлага хангасан, баталгаажуулсан үрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт худалддаг	0	5		
32.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэг	Үрийг худалдах, тээвэрлэхдээ түүний сав, баглаа боодлын шошго, дагалдах баримт бичигт тухайн үрийн сортын нэр, гарал үүсэл, чанар, ариутгал, сортын бүтээгчийн эрхээр хамгаалагдсан эсэх талаарх мэдээллийг тусгадаг	0	5		
33.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг	Химийн гаралтай бодис, цацрагаар ариутгасан үрийг савлаж багласан байх бөгөөд үрийн ариутгалын талаарх мэдээлэл, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг анхааруулсан болон тухайн үрийг ашиглахдаа баримтлах дарааллыг харуулсан зөвлөмжийг шошгод тусгах, эсхүл энэ тухай баримт бичгийг дагалдуулдаг	0	5		
34.	Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэг	Үр, сортын чанарыг баталгаажуулах үйл ажиллагааг хяналтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ	0	5		
35.	Газар тариалангийн үйлдвэрлэлд "Хөдөө аж	Таримал ургамлын ихэнх өвчин үр суулгацын материалаар	0	5		

	ахуйн зохистой дадал" /GAP/ нэвтрүүлэх зөвлөмжийн 2.3 дахь хэсэг	тархан халдварладаг учраас тарихын өмнө үрийг ариутгаж халдваргүйжүүлсэн тэмдэглэл хөтөлсөн дэвтэртэй				
36.	Газар тариалангийн үйлдвэрлэлд "Хөдөө аж ахуйн зохистой дадал" /GAP/ нэвтрүүлэх зөвлөмжийн 2.3 дахь хэсэг	Ургамал ургалтын үеийн өвчлөлт, хог ургамал, хортон шавьжаас хамгаалсан ургамал хамгааллын бодис хэрэглэсэн, авсан ариутгал хийсэн тухай тэмдэглэл хөтөлсөн дэвтэртэй	0	5		
37.	Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт	Таримлын үрийг таваас доошгүй жил тутам шинэчилсэн /үрийн аж ахуйн нь үрийн шинэчлэлийг сорт тус бүрээр гаргасан тэмдэглэлтэй	0	5		
38.	Үрийн буудай.Сортын болон үрийн чанар.Ерөнхий шаардлага MNS 0246:2010 стандартын 7.2 дахь хэсэг	Худалдан борлуулах болон хадгалах үрэнд гарал үүслийн тодорхойлолт, сорт, хянан баталгааны акт үрийн чанарын дүгнэлт дагалдуулсан байна	0	5		
<b>Дөрөв.Таримлын үрийн хорио цээрийн дэглэм, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал</b>			<b>0</b>	<b>24</b>		
39.	Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалт	Тариалангийн газарт хорио цээртэй өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал илэрсэн бол мэргэжлийн байгууллагад ажлын таван өдрийн дотор мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээг авсан	0	3		
40.	Ургамал хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2 дах заалт	Бүтээгдэхүүн нь хорио цээртэй ургамлын өвчин, хөнөөлт шавьжаар бохирдоогүй	0	3		
41.	Үрийн төмс.Сортын ба тариалалтын чанар. MNS885:2006 стандартын 6.3, 6.4, Үрийн буудай.Сортын болон үрийн чанар. MNS0246-2010 стандартын 5.3, 6.1, Шар луувангийн тарих үрийн чанар. Техникийн шаардлага MNS4717:2006 стандартын 5.3, 6.1, Улаан луувангийн тарих үрийн чанар.Техникийн шаардлага MNS4718:2006 стандартын 5.3, 6.1, Чинжүүний тарих үрийн чанар.Техникийн шаардлага MNS4720:2006 стандартын 5.2, 6.1 дэх хэсэг	Үйлдвэрлэсэн таримлын үр нь тарих үрийн чанар, стандартын шаардлагыг хангасан	0	3		
42.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, GAP ХАА-н зохистой дадал	Мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн хөтөлдөг	0	3		
43.	Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага	Агуулахад хортон шавьжийн устгал ариутгал халдваргүйтгэлийг хадгалж	0	3		

	MNS5364-2011 8.4 дэх хэсэг	байгаа бараа бүтээгдэхүүнд ямар нэгэн сөрөг нөлөө, бохирдолт үүсгэхгүй зөвшөөрөгдсөн бодисоор хийдэг				
44.	Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага MNS5364-2011 8.4 дэх хэсэг	Мэргэжлийн байгууллагатай хийсэн гэрээний дагуу тогтоосон хугацаанд хийдэг	0	3		
45.	Монгол Улсын Үрийн буудай. Сортын болон үрийн чанар.Ерөнхий шаардлага MNS0246:2010 стандартын 6.2 дахь хэсэг	Импортоор оруулах болон тариалах үр нь гадаад болон дотоод хорио цээртэй, хог ургамлын үрээр бохирлогдоогүй	0	3		
46.	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг	Ургамал хамгаалах химийн бодисыг зохих тун хэмжээгээр хэрэглэдэг	0	3		
<b>Тав.Хүнсний ногооны үрийн хадгалалтын технологи</b>			<b>0</b>	<b>30</b>		
47.	Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага MNS5364-2011 7.3 дахь хэсэг	Зооринд температур, харьцангуй чийг хэмжигч багажийг хаалга болон ууршуулагчаас хол, харагдахуйц газар байрлуулж хэмжилтийг өдөр бүр хийж, тэмдэглэл хөтөлдөг	0	5		
48.		Хяналтын самбар хэвийн ажилладаг /автомат удирдлагатай зоорины хувьд шалгана/	0	5		
49.	Үрийн төмс.Сортын ба тариалалтын чанар MNS885:2006 стандартын 8.2, 8.3 дахь хэсэг	Аж ахуйн нэгж байгууллага болон улсын үрийн нөөцийн агуулах зооринд хадгалах үрийн материалд хянан баталгааны акт болон холбогдох хяналтын байгууллагаас чанарын талаар дүгнэлтийг дагалдуулсан	0	5		
50.		Сортын үрийн төмсийг MNS ISO7562:2003 "Төмс зохиомол агааржуулагчтай зооринд хадгалах заавар" стандартын дагуу хадгалдаг	0	5		
51.	Улаан лувангийн тарих үрийн чанар. Техникийн шаардлага MNS4718:2006 стандартын 8.5, Шар лувангийн тарих үрийн чанар.Техникийн шаардлага MNS4717:2006 стандартын 8.5, Чинжүүний тарих үрийн чанар.Техникийн шаардлага MNS4720:2006 стандартын 8.5 дахь хэсэг	Үрийг өөр сортын үртэй холихгүйгээр 10°C-ээс 15°C хэмийн дулаантай байранд мэрэгчдээс хамгаалж, шалнаас 40 см-ээс 50 см хөндий тавиур дээр 3-аас илүүгүй үеэр, хананаас ба хажуу эгнээнээс 0.8 м-ээс 1.5 м зайтайгаар хурааж хадгалдаг	0	5		
52.		Доод тавиурын хөлд гөлмөн төмөр эсхүл хөнгөн цагаан төмрийг чийдэнгийн бүрхүүл хэлбэрээр хадаж мэрэгчдээс хамгаалдаг	0	5		
<b>Зургаа.Үр тарианы үрийг хадгалалтын технологи</b>			<b>0</b>	<b>55</b>		
53.	Үр тарианы хэвтээ (энгийн) агуулах. Техникийн шаардлага MNS6923:2021 стандартын 7.9 дэх хэсэг	Үр тариаг 2.5-3 м өндөр, 2.2 м өргөн нуруулдах бөгөөд шуудайд савласан үр тариаг 4-8 үеэр давхарлаж модон тавиур дээр хураах ба хананаас 2.5м-ийн зайтай байршуулсан	0	5		

54.	Үр тарианы босоо (силос) агуулахад тавих техникийн ерөнхий шаардлага MNS6924:2021 стандартын 7.12 дахь хэсэг	Үр тарианы босоо агуулах /силос/-т хадгалагдаж буй үр тариаг зориулалтын агааржуулах төхөөрөмж ашиглан технологийн дагуу салхилуулна. Зориулалтын төхөөрөмж байхгүй элеваторын силост байгаа үр тариаг хооронд нь сэлгэх замаар технологийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн салхилуулна. Үр тариаг технологийн дагуу сэлгэх нөөц савтай	0	5		
55.	Үр тарианы хэвтээ (энгийн) агуулах. Техникийн шаардлага MNS6923:2021 стандартын 5.6 дахь хэсэг	Тарих үрийн зориулалттай үр тариаг хадгалах агуулах нь таримлын сортуудыг хооронд нь холилдуулахгүй байх зорилгоор тусгаарлагдсан хана, модон хашлагатай байхаас гадна үр тарианы сорт тус бүрд ачиж буулгах машин механизм, дамжлагатай	0	5		
56.	Үр тарианы хэвтээ (энгийн) агуулах. Техникийн шаардлага MNS6923:2021 стандартын 7.12 дахь хэсэг	Үрийн материал хадгалж буй хашлага бүрд нэгээс доошгүй термометр тавина. Үүнийг үрийн доод (шалнаас 20-30 см дээш), дээд (гадаргуугаас 20-30 см доош), дунд талын давхаргаар байршуулсан	0	5		
57.	Үр тарианы хэвтээ (энгийн) агуулах. Техникийн шаардлага MNS6923:2021 стандартын 7.17 дахь хэсэг	Үр тариаг гаргахдаа хорио цээрийн үзлэг шинжилгээнд хамруулж, үрийг цэвэрлэн, нарлуулан гаргах бөгөөд шаардлагатай тохиолдолд ариутгал хийдэг	0	5		
58.	Үр тарианы хэвтээ (энгийн) агуулах. Техникийн шаардлага MNS6923:2021 стандартын 7.9 дэх хэсэг	Үр тариаг 2.5-3 м өндөр, 2.2 м өргөн нуруулах бөгөөд шуудайд савласан үр тариаг 4-8 үеэр давхарлаж модон тавиур дээр хураах ба хананаас 2.5м-ийн зайтай	0	5		
59.	Үр тарианы хэвтээ (энгийн) агуулах. Техникийн шаардлага MNS6923:2021 стандартын 7.10 дахь хэсэг	Шуудайтай савласан үрийг удаан хугацаанд хадгалбал 3 сар тутамд дээр нь байгаа шуудайтай үр тариаг доод талд, дунд талд байгааг гадна талд гаргаж, сэлгэлт хийж хадгалдаг тэмдэглэл хөтөлсөн дэвтэртэй	0	5		
60.	Үр тарианы хэвтээ (энгийн) агуулах. Техникийн шаардлага MNS6923:2021 стандартын 7.11 дэх хэсэг	Үр тариаг задгай болон нуруулдаж хадгалахад үрийн дотоод температур 8°C илүүгүй байдаг тэмдэглэлтэй	0	5		
61.	Үр тарианы хэвтээ (энгийн) агуулах. Техникийн шаардлага MNS6923:2021 стандартын 5.6 дахь хэсэг	Тарих үрийн зориулалттай үр тариаг хадгалах агуулах нь таримлын сортуудыг хооронд нь холилдуулахгүй байх зорилгоор тусгаарлагдсан хана, модон хашлагатай байхаас гадна үр тарианы сорт тус бүрд ачиж буулгах машин механизм, дамжлагатай	0	5		

62.	Үр тарианы хэвтээ (энгийн) агуулах. Техникийн шаардлага MNS6923:2021 стандартын 5.7 дахь хэсэг	Агуулах нь үр тариаг сэлгэлт хийх талбайтай	0	5		
63.	Үр тарианы хэвтээ (энгийн) агуулах. Техникийн шаардлага MNS6923:2021 стандартын 5.8 дахь хэсэг	Агуулахын хаалга нь автомашин, ачих, буулгах, сэлгэх механизмын хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх боломжтой дэлгэгддэг байх ба хаалганы босго нь шалны нэг түвшинд, хүн нэвтрэх хаалгатай	0	5		
<b>Долоо.Боловсон хүчний хангамж, ажиллагсдын эрүүл ахуйн нөхцөл</b>			<b>0</b>	<b>20</b>		
64.	Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалт	Хөдөө аж ахуйн инженер, агрономич, ургамал хамгааллын мэргэжилтэнтэй	0	4		
65.	Хөдөлмөрийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.1 дахь заалт, ХАА-н зохистой дадал GAP	Ажилтны мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, түүнд шинэ мэргэжил эзэмшүүлсэн	0	4		
66.	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын 3.1.1.5 дахь дэд заалт	Ажиллагсад хамгаалалтын хувцас, хэрэгслээр хангагдсан, хэрэглэж хэвшсэн	0	4		
67.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 17.2.3 дахь заалт	Бүх ажилчдад эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын зааварчилгаануудыг баримтжуулж өгсөн	0	4		
68.	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг	Бүх ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан	0	4		
<b>Найм.Бүтээгдэхүүний тээвэрлэлт, хаяг, шошго</b>			<b>0</b>	<b>18</b>		
69.	Ургамал хамгааллын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь заалт	Ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ авдаг	0	3		
70.	Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалт	Стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй	0	3		
71.	Үрийн төмс.Сортын ба тариалалтын чанар.Техникийн шаардлага MNS0885:2006 стандартын 8.4, Хөдөө аж ахуйн зохистой дадал /GAP/	Үрийн төмсийг MNS 0262:82 "Төмс хүнсний ногоог савлах, тээвэрлэх" стандартын дагуу савлаж, хөлдөхөөс хамгаалж тээвэрлэдэг	0	3		
72.		Төмс хүнсний ногооны үрийг тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь бүтээгдэхүүнийг бохирдох, элдэв механик гэмтэл үүсэх, халах, хөлдөж хайрагдах, хорхой шавьж нэвтрэхээс хамгаалсан зориулалттай	0	3		
73.		Тээврийн хэрэгсэл нь Төмс хүнсний ногоо тээвэрлэлт ангилал. Тээвэрлэлтийн нөхцөл.Ерөнхий шаардлага	0	3		



		MNS5648:2006 стандартын шаардлага хангасан				
74.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.9 дахь заалт	Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагын дагуу тээвэрлэн, хадгалдаг	0	3		
<b>Ес.Дотоод хяналт</b>			<b>0</b>	<b>10</b>		
75.	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Засгийн газрын 311 тогтоол	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг	0	5		
76.	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам, Засгийн газрын 311 тогтоол	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг	0	5		
<b>НИЙТ ОНОО</b>			<b>0</b>	<b>357</b>		

<b>БАТАЛГААЖУУЛАЛТ</b>		
<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хяналтын чиглэл, албан тушаалын нэр</i>	<i>Хүлээн зөвшөөрсөн: Аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан</i>
<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>	<i>/ овог, нэр/</i>
<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тэмдэг/</i>	<i>/ гарын үсэг, тамга/</i>

Тайлбар: